



МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН
НИЙГЭМЛЭГИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХҮНДЭТ
ЕРӨНХИЙЛӨГЧ, МУ-ЫН ТАТВАРЫН ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ
Я.МИШИГЛҮНДЭНГИЙН НЭРЭМЖИТ

“ТАТВАРЫН БҮРТГЭЛ-2017”

УЛСЫН IV ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

Олимпиадад оролцогчдын татвар, санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг ур чадварыг сорих, мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, заавар стандартын талаарх мэдлэгийг дээшлүүлж, хэрэглээ болгон идэвхижүүлэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Оролцогчдыг 2 бүлэгт хуваана.

1-р бүлэг: Нягтлан бодогч

2-р бүлэг: Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр суралцаж буй оюутан

ХЭЛБЭР, ХУГАЦАА:

Олимпиадыг 2 үе шаттай, нээлттэй зохион байгуулна.

1-р үе шат: 2017 оны 11-р сарын 16-нд 14:00 - 16:30 цагт /цахимаар/

2-р үе шат: 2017 оны 11-р сарын 23-нд 13:00 - 18:00 цагт /танхимд/

БҮРТГЭЛ:

Эхлэх хугацаа: 2017 оны 11-р сарын 01-ний 9:00 цаг

Дуусах хугацаа: 2017 оны 11-р сарын 15-ны 18:00 цаг хүртэл www.baaz.mn цахим хуудсаар үнэ төлбөргүй бүртгэнэ.

ШАЛГАРУУЛАЛТ:

1-р үе шат:

- Олимпиадыг нээх, хаах хугацааг урьдчилан тохируулсан тул зөвхөн товлосон хугацаанд оролцох боломжтой.
- Олимпиадын үргэлжлэх хугацаа 2 цаг 30 минут
- Оролцогч нь өөрийн байгаа газраас интернэтэд холбогдон оролцоно.
- Мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомж, журам стандартын талаарх мэдлэгийг шалгах 50 ширхэг энгийн асуулт, 50 ширхэг бодолттой асуулт бүхий цахим тест ажиллах хэлбэрээр явагдана.
- Тестийг програмын аргаар автоматаар дүгнэнэ.
- Тестийн зөв хариултыг шалгаруулалтын дараа www.cpta.mn цахим хуудсанд нээлттэй байршуулна.
- Нийт оролцогчдын дүнг бүртгэлийн дугаараар шалгаруулалт хаагдсанаас хойш 24 цагийн дотор www.cpta.mn цахим хуудсанд нээлттэй мэдээнэ.
- 1-р шатны шалгаруулалтаас бүлэг тус бүрээс хамгийн өндөр үнэлгээ авсан 20 оролцогч 2-р үе шатанд оролцох эрх авна.

2-р үе шат:

- 2-р үе шатанд оролцогчдыг www.cpta.mn, www.baaz.mn www.mta.mn цахим хуудсуудад нээлттэй зарлана.
- 2-р шатанд оролцогч нь зохион байгуулагчдын зарласан газарт /танхимд/ иргэний үнэмлэхтэй, өөрийн биеэр ирж оролцоно.
- ВААЗ санхүү, бүртгэлийн цахим систем дээр татвар ногдуулалт, тайлагнал, бүртгэл бүхий цогц бодлого бодож, татварын тайлангийн маягт бөглөх хэлбэрээр явагдана.
- Цогц бодлогын хариуг зохион байуулагчдын тогтоосон шалгуураар дүгнэнэ.
- Бүлэг тус бүрт хамгийн өндөр оноо авсан 2 оролцогчийг шалгаруулна.
- 2-р шатны дүнг шалгаруулалт хаагдсанаас хойш 24 цагийн дотор www.cpta.mn, сайтаар нээлттэй мэдээлнэ.
- Олимпиад дууссаны дараа дүгнэх шалгуурыг www.cpta.mn, www.baaz.mn цахим хуудсуудад нээлттэй байршуулна.

ШАГНАЛ:

1-р бүлэг Нягтлан бодогч:

- 1-р байр: Өргөмжлөл, 800,000 төгрөг,
ВААЗ системийг ашиглах 800,000 төгрөгийн эрх
- 2-р байр: Өргөмжлөл, 500,000 төгрөг,
ВААЗ системийг ашиглах 500,000 төгрөгийн эрх
- Тусгай байр: ТМЗН-с зохион байгуулагдаж буй төлбөртэй сургалтад суух 200,000 төгрөгийн эрхийн бичиг, ВААЗ системийг ашиглах 200,000 төгрөгийн эрх,

2-р бүлэг Оюутан:

- 1-р байр: Өргөмжлөл 500,000 төгрөг,
ВААЗ системийг ашиглах 500,000 төгрөгийн эрх
- 2-р байр: Өргөмжлөл, 300,000 төгрөг,
ВААЗ системийг ашиглах 300,000 төгрөгийн эрх
- Тусгай байр: ТМЗН-с зохион байгуулагдаж буй төлбөртэй сургалтад суух 100 000 төгрөгийн эрхийн бичиг, ВААЗ системийг ашиглах 100,000 төгрөгийн эрх

Санаачлагч- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг

Хамтран зохион байгуулагч- “Новасофт” ХХК

Дэмжигч- Сангийн яам, Татварын ерөнхий газар

Холбоо барих

Утас: 76118989, 70007001

Цахим хуудас: www.cpta.mn, www.baaz.mn, www.facebook.com/baaz.mn